

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/01/НА-СТА-ТШЗ

Цахим
хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр
аймаг

2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:baranbayarg@audit.gov.mn)
Аудитор: С.Батцэцэг
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

АЙМГИЙН "ПРОКУРОРЫН
ГАЗАР"-ЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Т.ХҮСЛЭН ТАНАА

2023.02.24 № 08
танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус газар нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020029

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	29.21	29.23
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,816.54	2,165.71
	Нийт хөрөнгийн дүн	1,845.75	2,194.94
	Нийт өр төлбөрийн дүн	0.20	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,845.55	2,194.94
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,845.75	2,194.94
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,298.18	1,044.05
	Үйл ажиллагааны зардлын дүн	646.86	705.46
	Үйл ажиллагааны үр дүн	1,651.32	338.59
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,651.32	338.59
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194.23	1,845.55
	Тайлант оны үр дүн	1,651.32	338.59
	Эцсийн үлдэгдэл	1,845.55	2,184.14
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	681.43	663.81
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	637.51	638.04
	Үйл ажиллагааны ЦМГ	43.92	25.77
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	43.92	25.77
25,	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.00	0.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	673.91	651.18
	Урсгал зардал	673.91	651.18
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	673.91	651.18
	Улсын төсвийн санхүүжих	673.91	651.18
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	.00	0.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Прокурорын газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Тухайн нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилтууд

1. “Байгууллагын үйл ажиллагааг их өгөгдөлд суурилсан бодлогын инновацаар удирдах”
2. “Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх ”
3. “Прокурорын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй, хялбар болгох”
4. “Прокурор, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, нийгмийн хөгжлийн шинэ хандлагад хувь хүнийг төлөвшүүлэх”

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд аудитад баримтлах ерөнхий чиглэл”, МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаал баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-т тусгасан асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг зөрчил илрээгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2022 онд ажил гүйцэтгэх гэрээ, худалдан авалтын гэрээ, үйлчилгээний гэрээг байгуулж 21,530.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсныг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-

ын 3.2.11 дэх заалтыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн мэдээлсэн байдлын хэрэгжилт 72.0 хувьтай байгаа тул хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

5.2.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүйгээс 3,684.8 мянган төгрөгийн худалдан авалтыг илүү, дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5., Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулж албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

..Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 30,502.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс завсрын аудитаар 6,784.2 мянга, аудитын явцад 23,718.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Эзэмшлийн 900м² газрыг нэмэгдүүлэх хүсэлт өгсний дагуу АЗД-ын 2022.07.21-ний өдрийн №А/227 захирамжаар 1800м² болгож нэмэгдүүлснийг 21,600.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгахдаа Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансыг нэмэгдүүлж буруу тайлагнасныг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын хавсралтын дагуу Засгийн газрын оруулсан капиталын дансанд бүртгэж залруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтуудыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Цалингийн зардлын кредит дансанд 2,118.4 мянга төгрөгөөр тайлагнасныг тооцооны дансаар дамжуулж залруулж тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалтуудыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 669.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 669.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож байна.

7.2Төлбөрийн акт

- Жолоочийн тооцооны хуудсаар шатахуун зарцуулалтыг тулган баталгаажуулахад МУЕП-ын 2020.04.01-ний өдрийн №А/09 тушаалаар батлагдсан нормыг баримтлаагүйгээс 669.2 мянган төгрөгийн шатахууныг хүчин төгөлдөр бус баримтаар давхардуулан илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4” дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

7.3 Албан шаардлага өгөөгүй.

7.4 Зөвлөмж өгөөгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

8 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	4	31.17	3	30.50	1	0.67				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	2	25.21					2	25.2		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	2	25.21					2	25.21		
	НИЙТ ДҮН	6	56.38	3	30.50	1	0.67	2	25,21		